



## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;  
Зөвшөөрлийн тухай хууль;  
Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль.

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Эдийн засаг, хөгжлийн яам

Нэгжийн нэр:

Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газар

Албан тушаалын нэр:

Эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого хариуцсан мэргэжилтэн (ОХУ)

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлох, нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, түнш орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, зээл, тусламжийн бодлогыг тодорхойлох, холбогдох гэрээ, хэлэлцээрийг эцэслэн тохирч байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах чиг үүргийг хэрэгжүүлж гүйцэтгэлийн үр дүнг Газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлох, хамтын ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, хэрэгжилтийн үр ашгийг сайжруулах чиглэлээр судалгаа, дүн шинжилгээ хийж санал боловсруулах;
- 2.Худалдаа, эдийн засаг, хөгжлийн санхүүжилтийн асуудлаар түнш орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, удирдлагын шийдвэр гаргалтад мэргэшлийн зөвлөгөө үзүүлэх;
- 3.Хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийх арга хэмжээг уялдуулах, төслийг хэрэгжүүлэх арга хэмжээг оролцогч талуудын хамт тодорхойлох, холбогдох санхүүжилтийн гэрээ, хэлэлцээрийг эцэслэн тохирч байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- 4.Яамны болон нэгжийн дотоод үйл ажиллагаанд оролцох, тайлагнах, хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Монгол Улсын хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлох, хамтын ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах;	Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлох, хамтын ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, хэрэгжилтийн үр ашгийг сайжруулах чиглэлээр судалгаа, дүн шинжилгээ хийж санал боловсруулах	Г, Х
	2.Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, хэрэгжилтийн үр ашгийг сайжруулах чиглэлээр судалгаа дүн шинжилгээ хийх, санал боловсруулах;		Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Худалдаа, эдийн засаг, хөгжлийн санхүүжилтийн асуудлаар түнш улс орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллага тус бүрийн болон тэдгээртэй хийж буй хамтын ажиллагааны мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулалтыг тухай бүр хийх, удирдлагыг мэдээллээр хангах;	Худалдаа, эдийн засаг, хөгжлийн санхүүжилтийн асуудлаар түнш орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, удирдлагын шийдвэр гаргахад мэргэшлийн зөвлөгөө үзүүлэх	Г, Х



	2.Худалдаа, эдийн засаг, хөгжлийн санхүүжилтийн асуудлаар түнш орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллага тус бүртэй хийх хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх боломжийн талаар судалгаа, дүн шинжилгээ хийх, санал боловсруулах;		Г, Х
	3.Худалдаа, эдийн засаг, хөгжлийн санхүүжилтийн асуудлаар түнш орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хийх уулзалтуудыг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах, удирдлагуудыг мэдээллээр хангах.		Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Хөгжлийн түншүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, санхүүжилтийн шинэ эх үүсвэр эрэлхийлэх арга хэмжээг зохион байгуулах, санал боловсруулах;	Хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийх арга хэмжээг уялдуулах, төслийг хэрэгжүүлэх арга оролцогч талуудын хамт тодорхойлох, холбогдох санхүүжилтийн гэрээ, хэлэлцээрийг эцэслэн тохирч байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Г, Х
	2.Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Монгол Улсын хөгжлийн бодлого болон Хөгжлийн түншүүдтэй байгуулсан дунд хугацааны түншлэлийн стратегитай уялдуулах, төслийг хэрэгжүүлэх арга хэмжээг оролцогч талуудын хамт тодорхойлох, санал боловсруулах;		Г, Х
	3.Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээ, хэлэлцээрийг эцэслэн тохирч байгуулахад дэмжлэг үзүүлэх;		Г, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Тушаал шийдвэр, цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;	Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна.	

2.Нэгжийн даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, арга хэмжээний биелэлтийг хангах, тогтоосон хугацаанд нь тайлагнах, үр дүнг үнэлж дүгнүүлэх;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, арга хэмжээний биелэлтийг хангаж, тогтоосон хугацаанд нь тайлагнах, үр дүнг үнэлж дүгнүүлсэн байна.	Г
3.Төрийн албаны тухай хууль болон төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрэм журам, байгууллагын дотоод журам, бусад төрийн албаны стандартыг мөрдөж хэрэгжүүлэх;	Төрийн албаны тухай хууль болон бусад стандарт дүрэм, журмыг зөрчөөгүйг нотлох дүгнэлт гаргасан байна.	Г
4.Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, төрийн албаны хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллах;	ХОМ хугацаанд нь мэдүүлж, ёс зүйн зөрчилгүй ажилласан байна.	Г
5.Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн баримт бичгийн төсөл төлөвлөх, архивын нэгж бүрдүүлэх, байгууллага нэгжийн өдөр тутмын дотоод үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах;	Албан хэрэг хөтлөлийн заавар журам, стандартад нийцсэн байна.	Г
6.Мэргэжлийн болон хувь хүний мэдлэг, боловсрол, ур чадвараа тогтмол дээшлүүлэх.	Мэргэжлийн болон хувь хүний мэдлэг, боловсрол, ур чадвараа тогтмол дээшлүүлэн ажилласан байна.	Г

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

<b>Боловсрол</b>	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй
<b>Мэргэжил</b>	- Эдийн засаг /031101/; - бизнес ба удирдахуй /041201, 041202, 041203, 041301, 041303, 041601/; - эрх зүй /0421/; - улс төр, иргэн судлал /031201, 031202/; - байгалийн шинжлэх ухаан, математик, статистикт хамаарах салбар дундын чиглэл /058802/.
<b>Мэргэшил</b>	-
<b>Туршлага</b>	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.



<b>Ур чадвар</b>	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх, нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;</li> <li>- судалгааны ерөнхий арга зүй эзэмшсэн байх;</li> <li>- тоон мэдээлэлтэй ажиллах, нэгтгэн дүгнэх, статистикийн арга хэрэгслийг ашиглах чадвартай байх.</li> </ul>
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, бусад хуулийг чандлан баримталж үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх;</li> <li>- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих;</li> <li>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх;</li> <li>- шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх;</li> <li>- өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх;</li> <li>- бүтээлч, санаачилгатай ажиллах;</li> <li>- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах.</li> </ul>
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- хувийн зан төлөв, ажил хэрэгч чанар, зарчимч, тууштай байдал, ажлын цаг ашиглалтын хувьд нэгжийн хамт олныг үлгэрлэх;</li> <li>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх;</li> <li>- багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх;</li> <li>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;</li> <li>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- нээлттэй, шударга, хамт олонч сэтгэлгээтэй байх.</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- албан ажлын чиг үүргийнхээ дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;</li> <li>- орос хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх /Бусад хэлний мэдлэгтэй бол давуу тал болно./;</li> <li>- компьютерын болон албан хэрэглээний программ хангамж болон бусад зайлшгүй шаардлагатай ур чадвар;</li> <li>- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх.</li> </ul>

#### **V.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ**

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:


Бусад харилцах субъект

- Төрийн болон орон нутгийн байгууллага, тэдгээрийн холбогдох албан тушаалтан;
- Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, олон улсын байгууллага, тэдгээрийн холбогдох албан тушаалтан;
- Гадаад улс орнуудын төрийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн холбогдох албан



тушаалтан, гадаадын иргэн, хуулийн этгээд;  
- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.

**V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**


<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА  2023 оны 10 дугаар сарын 31-ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: 23 1006 Дугаар: 417

Байгууллагын нэр: ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

Шийдвэрийн огноо: 2023.10.31

Дугаар: А/213

(тамга/ тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  (И.БАТХҮҮ)

2023 оны 10 дугаар сарын 31-ны өдөр

